

Шинэ Гэрээний төгс эзэмших сургаал: 2-р үнэлгээний шалгалт

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Төгс эзэмших сургаалын судрын эшлэл

1–3-р асуултын хувьд, үг хэллэг тус бүрийн хажуу дахь хоосон зайд холбогдох эшлэлийн үсгийг бич. Үнэлгээний шалгалтын энэ хэсэгт судраа ашиглаж болохгүй.

- | | |
|--|--------------------|
| 1. ____ “Итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм.” | а. 1 Коринт 11:11 |
| 2. ____ “Цагийн дүүрлийг гүйцэлдүүлэхийн тулд ... бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ.” | б. Ефес 1:10 |
| 3. ____ “Эзэн дотор эр хүнгүйгээр эм хүн гэж үгүй бөгөөд эм хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм.” | в. 2 Тимот 3:15–17 |
| | г. Иаков 2:17–18 |
| | д. Илчлэл 20:12 |

Судрын түлхүүр үг хэллэг

4–6-р асуултын хувьд, төгс эзэмших сургаалын судрын түлхүүр үг хэллэгийн дутуу орхисон үгсийг нөхөж бич. Үнэлгээний шалгалтын энэ хэсэгт судраа ашиглаж болохгүй.

- “Та нарын _____ бол _____.” (1 Коринт 6:19–20).
- Сүм бол “_____ нар болон _____ эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд _____ Өөрөө булангийн чулуу нь ажээ” (Ефес 2:19–20).
- “Эхлээд _____ гарахаас нааш _____ өдөр _____ ирэхгүй” (2 Тесалоник 2:1–3).

Та судруудаа үнэлгээний шалгалтын үлдсэн хэсэгт ашиглаж болно.

7–9-р асуултын хувьд, дараах нөхцөл байдалд орсон хүнд туслах төгс эзэмших сургаалын судрын нэг эсвэл хэд хэдэн хэсгийг тодорхойл.

7. Найзын тань хайрладаг хүн саяхан нас баржээ. Таны найзад үхлийн дараа бидэнд юу тохиолддог талаар олон асуулт байна.	
8. Танай ахад хэцүү байгаа бололтой. Тэр Бурхан үнэхээр түүнийг мэддэг эсэхэд эргэлзэж байна.	
9. Буруу үзэл санаа, уруу таталттай тулгарах үедээ хэрхэн итгэлтэй хэвээр үлдэж болох талаар ирэх Ням гаргийн ангийн хичээлээр ангийнхандаа зөвлөгөө өгөхийг танаас Сүмийн удирдагч хүсжээ.	

10–11-р асуултын хувьд, сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг ашиглах мэдлэг, чадвараа харуул.

10. Сүнслэг мэдлэг олж авах дараах гурван зарчмын талаар ямар ч мэдлэггүй хүнд та тэдгээрийг хэрхэн тайлбарлах байсан бэ?

а. Итгэлээр үйлдэх

б. Утга санаа болон асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах

в. Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн гүнзгий ойлголттой болохыг эрэлхийлэх

11. Танд ахлах сургуулиа удахгүй төгсөх гэж байгаа найз байдаг бөгөөд тэр дараагийн хэдэн жил амьдралдаа гаргах чухал шийдвэрүүдийнхээ талаар санаа зовж байгаа аж. Дараах асуултуудад хариул.

а. Итгэлээр үйлдэхийн тулд та түүнийг яг ямар тодорхой зүйлийг хийхэд урих байсан бэ?

б. Та түүнд нөхцөл байдлаа мөнхийн талаас нь шинжлэн судлахад хэрхэн тусалж чадах вэ?

в. Төгс эзэмших сургаалын хэсгүүд бол тэнгэрээс томилогдсон эх сурвалжийн нэгэн жишээ юм. Та найздаа төгс эзэмших сургаалын судрын аль хэсгийг хуваалцаж болох вэ? Яагаад?

12. Энэ улиралд судалсан төгс эзэмших сургаалын судрын 13 хэсгээс тань аль нь танд хамгийн их нөлөөлсөн бэ, мөн яагаад? Судрын уг хэсэг танд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын талаар юу заадаг вэ?